



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/213-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: Ч.Цэрэннадмид Утас: 95112689 Цахим хаяг: ts.nadiii@yahoo.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал.....	14
3.4. Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	17
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал.....	187
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4.2 Албан шаардлага, зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
БСГ	Боловсрол соёлын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ШААМАР СУМЫН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.БОЛОРМАА ТАНАА

2022.02.25 № СЭА-2022/213-НА-СТА-ТШЗ
тантай _____-ны № _____-ийг

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,539,998.50	30,558,178.22
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-	-
311	Кассад байгаа	-	
312	Банканд байгаа		
33	АВЛАГА	-	54,423.72
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
335	Бусад авлага	-	54,423.72
35	БАРАА МАТЕРИАЛ	25,539,998.50	30,503,754.50
351	Түүхий эд материал	-	-
35110	Тусгай зориулалттай материал	-	-
354	Хангамжийн материал	25,539,998.50	30,503,754.50
35410	Бичиг хэргийн материал	108,000.00	-
35420	Аж ахуйн материал	19,070,848.50	20,608,648.50
35460	Хүнсний материал	269,690.00	710,946.00
35470	Бусад хангамжийн материал	6,091,460.00	9,184,160.00
356	Мал амьтад	-	-
36	НӨӨЦИЙН БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	333,896,395.90	325,255,900.34
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	333,896,395.90	325,255,900.34
392	Биет хөрөнгийн дүн	323,392,395.90	314,751,900.34
39201	Барилга байгууламж	273,357,400.00	273,357,400.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14,387,231.52)	(21,580,847.28)
39205	Машин тоног төхөөрөмж	44,800,343.59	52,120,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(18,949,064.73)	(25,393,909.37)
39207	Тавилга, эд хогшил	12,394,932.16	12,871,226.28
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,789,643.04)	(7,247,900.81)
39209	Зам, гүүрийн байгууламж	6,477,900.00	6,477,900.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	-
39214	Бусад үндсэн хөрөнгө	39,017,093.00	38,086,893.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(11,269,749.56)	(14,702,877.48)
39217	Ном	740,416.00	763,816.00
393	Биет бус хөрөнгийн дүн	10,504,000.00	10,504,000.00
39301	Программ хангамж	-	-
39302	Хасагдуулга	-	-
39303	Бусад биет бус хөрөнгө	10,504,000.00	10,504,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	359,436,394.40	355,814,078.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
41361	Байгууллагад төлөх өглөг		
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	359,436,394.40	355,814,078.56
51	Засгийн газрын хувь оролцоо	359,436,394.40	355,814,078.56
511	Засгийн газрын оруулсан капитал	72,194,770.87	72,194,770.87
51101	Өмч: -төрийн	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	10,923,999.96	7,301,684.12
51210	Өмнөх үеийн үр дүн	16,695,773.16	10,923,999.96
51220	Тайлант үеийн үр дүн	(5,771,773.20)	(3,622,315.84)
51300	Дахин үнэлгээний зөрүү	276,317,623.57	276,317,623.57
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	359,436,394.40	355,814,078.56

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	345,110,181.80	327,973,456.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,204,605.40	11,948,766.00
120	Нийтлэг татварын бус орлого	16,204,605.40	11,948,766.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	16,204,605.40	11,948,766.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	5,276,500.00	4,565,620.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	10,928,105.40	7,383,146.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	328,905,576.40	316,024,690.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	308,379,300.00	291,728,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	308,379,300.00	291,728,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	942,172.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		942,172.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,526,276.40	23,354,218.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,526,276.40	23,354,218.90
2	Үйл ажиллагааны зардал	350,881,955.00	331,595,772.74
21	Урсгал зардал	350,881,955.00	331,595,772.74
210	Бараа, үйлчилгээний зардал	319,627,877.63	315,092,083.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	225,213,608.00	223,324,181.00
210101	Үндсэн цалин	171,344,573.00	151,187,652.00
210102	Нэмэгдэл цалин	36,744,935.00	56,138,982.00
210104	Урамшуулал	17,124,100.00	15,997,547.00
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	27,813,834.63	28,924,907.93
210201	Тэтгэврийн даатгалын	19,254,398.04	20,264,365.73
210202	тэтгэмжийн даатгалын	2,227,235.64	2,235,389.94
210203	ҮОМШӨ-ий даатгалын	1,831,400.23	1,814,495.42
210204	Ажилгүйдлийн даатгалын	409,161.46	388,386.66
210205	ЭМ-ийн даатгалын	4,091,639.26	4,222,270.18
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,586,276.40	20,252,618.90
210301	Гэрэл цахилгааны зардал	2,492,767.40	2,417,418.90
210302	Түлш, халаалтын зардал	16,033,509.00	16,835,200.00
210303	Цэвэр бохир усны зардал	60,000.00	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,973,779.07	4,778,491.00
210401	Бичиг хэргийн зардал	706,850.00	1,037,200.00
210404	Тээвэр шатахуун	226,800.00	176,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	1,018,200.00	932,200.00
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	237,500.00	542,100.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлийн зардал	1,001,900.00	1,499,091.00

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	5,746,165.40	591,500.00
210408	Бараа материал акталсны зардал	36,363.67	-
2105	Нормативт зардал	12,660,730.00	10,418,714.00
210502	Хоол, хүнс	11,081,290.00	9,111,814.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	904,940.00	338,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	674,500.00	968,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,420,400.00	3,568,499.99
210601	Багаж техник, хэрэгсэл	47,000.00	87,499.99
210604	Урсгал засварын зардал	4,373,400.00	3,481,000.00
2107	Томилолтын зардал	32,900.00	60,200.00
210702	Дотоодын томилолт	32,900.00	60,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	1,227,505.00	996,755.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	157,800.00	348,755.00
210802	Аудит баталгаажуулалтын зардал	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	745,705.00	
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	20,698,844.53	22,767,715.57
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	709,850.00	
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	-	525,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,988,994.53	22,242,015.57
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	31,254,077.37	16,503,689.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,254,077.37	16,503,689.35
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг		
3	Үйл ажиллагааны үр дүн	(5,771,773.20)	(3,622,315.84)
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225001	Үнэ төлбөргүй гарсан зардал-Үндсэн хөрөнгө		
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал		
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	(5,771,773.20)	(3,622,315.84)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	328,905,576.40	316,024,690.90
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	328,905,576.40	316,024,690.90
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	308,379,300.00	291,728,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	308,379,300.00	291,728,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	942,172.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		942,172.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,526,276.40	23,354,218.90
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,526,276.40	23,354,218.90
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	324,646,676.40	306,901,290.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	324,646,676.40	306,901,290.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	293,392,599.03	290,397,601.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	225,213,608.00	223,324,170.00
210101	Үндсэн цалин	171,344,573.00	150,860,104.00
210102	Нэмэгдэл	36,744,935.00	56,466,519.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	17,124,100.00	15,997,547.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,813,834.63	28,979,342.65
210201	Тэтгэврийн даатгалын	19,017,411.04	20,252,383.52
210202	Тэтгэмжийн даатгалын	2,373,549.28	2,250,276.81
210203	ҮОМШӨ-ий даатгалын	1,865,236.77	1,792,775.60
210204	Ажилгүйдлийн даатгалын	414,331.40	437,698.74
210205	Эрүүл мэндийн даатгалын	4,143,306.14	4,246,207.98
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,526,276.40	20,252,618.90
210301	Гэрэл цахилгааны зардал	2,492,767.40	2,417,418.90
210302	Түлш, халаалтын зардал	16,033,509.00	16,835,200.00
210303	Цэвэр бохир усны зардал		1,000,000.00
2104	Хангамж, бараа материал	2,604,400.00	1,882,400.00
210401	Бичиг хэргийн зардал	76,900.00	78,000.00
210404	Тээвэр шатахуун	226,800.00	176,400.00
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл технологийн үйлчилгээ	62,300.00	932,200.00
210404	Ном		33,300.00
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,100,000.00	522,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,138,400.00	140,400.00
2105	Нормативт зардал	10,511,680.00	10,126,270.00
210501	Эм	49,000.00	49,700.00
210502	Хоол, хүнс	9,946,680.00	9,553,070.00
210503	Нормын хувцас	516,000.00	523,500.00
2106	Эд хогшил урсгал засвар	4,570,400.00	3,481,000.00
210601	Багаж техник хэрэгсэл	197,000.00	-
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		
210604	Урсгал засвар	4,373,400.00	3,481,000.00
2107	Томилolt, зочны зардал	-	60,200.00

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоодын томилолт	-	60,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	1,869,700.00	948,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	295,700.00	300,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	648,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,250,000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,282,700.00	1,343,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	955,900.00	
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	1,326,800.00	1,343,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,254,077.37	16,503,689.35
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2133	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт	31,254,077.37	16,503,689.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,254,077.37	16,503,689.35
22	Хөрөнгийн зардал	-	-
2220	Дотоод эх үүсвэрээр	-	-
222001	Тоног төхөөрөмж		
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		
225107	Тоног төхөөрөмж		
225108	Бусад хөрөнгө		
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	4,258,900.00	9,123,400.00
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	4,258,900.00	9,123,400.00
22	Хөрөнгийн зардал	4,258,900.00	9,123,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,258,900.00	9,123,400.00
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,258,900.00	(9,123,400.00)
222001	Тоног төхөөрөмж	-	-
223001	Бусад хөрөнгө	4,258,900.00	9,123,400.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(4,258,900.00)	(9,123,400.00)
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	(0.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2019 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	16,695,773.16	365,208,167.60
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(5,771,773.20)	(5,771,773.20)
2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	10,923,999.96	359,436,394.40
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(3,622,315.84)	(3,622,315.84)
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	72,194,770.87	276,317,623.57	7,301,684.12	355,814,078.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	317,117,300.00	298,578,829.55	18,538,470.45	94.2
21	Урсгал зардлын дүн	317,117,300.00	298,578,829.55	18,538,470.45	94.2
210	Бараа үйлчилгээний зардал	317,117,300.00	298,578,829.55	18,538,470.45	94.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,800,100.00	222,643,129.00	10,156,971.00	95.6
210101	Үндсэн цалин	177,489,500.00	150,860,104.00	26,629,396.00	85.0
210102	Нэмэгдэл	37,956,300.00	55,785,478.00	(17,829,178.00)	147.0
210104	Урамшуулал	17,354,300.00	15,997,547.00	1,356,753.00	92.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,385,400.00	28,894,211.65	1,491,188.35	95.1
210201	Тэтгэврийн даатгал	21,073,400.00	20,194,494.52	878,905.48	0.0
210202	Тэтгэмжийн даатгал	2,328,000.00	2,243,466.81	84,533.19	0.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,862,400.00	1,791,413.60	70,986.40	0.0
210204	Ажилгүйдлийн даатгал	465,600.00	424,077.74	41,522.26	0.0
210205	ЭМД-ын хураамж+В21	4,656,000.00	4,240,758.98	415,241.02	0.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,287,400.00	20,252,618.90	2,034,781.10	90.9
210301	Гэрэл цахилгааны зардал	4,452,200.00	2,417,418.90	2,034,781.10	0.0
210302	Түлш, халаалтын зардал	16,835,200.00	16,835,200.00	-	0.0
210303	Цэвэр бохир усны зардал	1,000,000.00	1,000,000.00	-	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	1,729,800.00	1,729,800.00	-	100.0
210401	Бичиг хэрэг	78,000.00	78,000.00	-	0.0
210402	Тээвэр шатахуун	176,400.00	176,400.00	-	0.0
210403	Шуудан холбоо	932,200.00	932,200.00	-	0.0
210404	Ном	56,700.00	56,700.00	-	0.0
210405	Хог хаягдал	346,100.00	346,100.00	-	0.0
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	140,400.00	140,400.00	-	0.0
2105	Нормативт зардал	14,638,300.00	10,126,270.00	4,512,030.00	69.2
210501	Эм	49,700.00	49,700.00	-	0.0
210502	Хоол хүнс	14,065,100.00	9,553,070.00	4,512,030.00	67.9
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	523,500.00	523,500.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,581,000.00	12,581,000.00	-	100.0
210601	Багаж хэрэгсэл	6,500,000.00	6,500,000.00	-	100.0
210602	Тавилга	2,600,000.00	2,600,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл			-	
210604	Урсгал засвар	3,481,000.00	3,481,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	79,700.00	60,200.00	19,500.00	75.5
210702	Дотоод томилолт	79,700.00	60,200.00	19,500.00	75.5

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	1,272,000.00	948,000.00	324,000.00	74.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	300,000.00	300,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	972,000.00	648,000.00	324,000.00	66.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,343,600.00	1,343,600.00	-	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал			-	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,343,600.00	1,343,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	317,117,300.00	298,578,829.55	18,538,470.45	94.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	291,728,300.00	275,224,610.65	16,503,689.35	94.3
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	291,728,300.00	275,224,610.65	16,503,689.35	94.3
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	25,389,000.00	23,354,218.90	2,034,781.10	91.99
132001	Орон нутгийн төсвөөс	25,389,000.00	23,354,218.90	2,034,781.10	23354218.90
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.00	22.00	-	100.0
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	8.00	8.00	-	100.0
	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.0
010	СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДҮНДЖААР/	97.00	97.00	-	100.0
015	Төрийн өмчит СӨБ байгууллага	97.00	97.00	-	100.0
024	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	22.00	22.00	-	100.0
028	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	22.00	22.00	-	100.0
033	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	-	-	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Мөнгө	-	942,172.00	(942,172.00)
II. Нийт зарлагын дүн	-	942,172.00	(942,172.00)
IV. Урсгал зардлын дүн	-	942,172.00	(942,172.00)
Бараа үйлчилгээний зардал		942,172.00	(942,172.00)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	681,042.00	(681,042.00)
Цалин хөлс		681,042.00	(681,042.00)
нэмэгдэл			-
Унаа хоолны хөнгөлөлт			
урамшуулал			-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		85,130.00	(85,130.00)
Тэтгэврийн даатгал		57,889.00	(57,889.00)
Тэтгэмжийн даатгал		6,810.00	(6,810.00)
ҮОМШӨ-ний даатгал		1,362.00	(1,362.00)
Ажилгүйдлийн даатгал		13,621.00	(13,621.00)
ЭМД-ын хураамж		5,448.00	(5,448.00)
тогтмол зардлын дүн		-	-
Хангамж, бараа материалын зардал	-	-	-
Нормативт зардал	-	176,000.00	(176,000.00)
Эм		176,000.00	(176,000.00)
Хоол			-
Нормын хувцас зөөлөн эдлэл			-
Эд хогшил худалдан авах	-	-	-
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	942,172.00	(942,172.00)
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	942,172.00	
Төсвөөс санхүүжих			-
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө		942,172.00	(942,172.00)
НД-ын сангаас			-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос			-
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн /цаашид Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг гэх/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн төлбөрийн цахим баримт, шилэн данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн захирал аудитор Ч.Цэрэннадмид, аудитор Э.Эрдэнэбат нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “ЦЭСБ-Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь “Багшийн харилцаа хандлага ур чадвар заах арга зүйг дээшлүүлж хүүхэд нэг бүрийн хөгжил төлөвшилд ахиц гаргах” гэж зорилгоо тодорхойлсон байна.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хөгжлийн бодлого, чиглэл, сургалтын үйл ажиллагаа
- Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт
- Мэргэжилтэй боловсон хүчнээр хангах, түүний хэрэгжилт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангасан байдал
- Цэцэрлэгт орон нутгийн харилцаа холбоог бэхжүүлэх талаар хийсэн ажлын агуулга, үр дүн
- Багш хөгжил, хүүхдийн хөгжлийн чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, эцэг эх, асран хамгаалагч нартай хамтран хийж, хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ
- Хүүхэд нэг бүрийн авьяас ур чадварыг хөгжүүлэх чиглэлээр хийгдэж буй ажил үйлчилгээ

- Хүүхдийн хоол хүнсний аюулгүй байдал, зөв хооллолтын талаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаа
- Цэцэрлэг, орон нутаг, төрийн болон төрийн бус байгууллагын харилцаа холбоог бэхжүүлэх талаар хийсэн ажил, хөрөнгө оруулалт
- Хөрөнгө оруулалт, шинээр санаачлан хийсэн ажил үйлчилгээ, тохижилт

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт.
- БШУ-ны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2021 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн А/05, А/10, 1 тоот хамтарсан тушаал "Шалгуур үзүүлэлт шинэчлэх тухай" ур чадвар
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- "Нийгмийн даатгалын тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 32 дугаар зүйлийн 1 дүгээр зүйлээр НДШ-ийн хувь хэмжээнд өөрчлөлт орсон, Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн А/58 дугаар захирамжаар баталсан "Сэлэнгэ аймгийн орон нутгийн төсөвт байгууллагуудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 350,881.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 3,508.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,456.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,622.3 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал, үндсэн хөрөнгө дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Хувь хүнээс авах авлага		54,4	
Татаас санхүүжилтийн авлага			
Байгууллагаас авах авлага		-	-
Урьдчилж төлсөн зардал			
Бараа материал	25,540.0	30,503.7	4,963.7
Үндсэн хөрөнгө	333,896.4	325,255.9	(8,640.5)
Нийт хөрөнгө	359,436.4	355,814.1	(3,622.3)
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	359,436.4	355,814.1	(3,622.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	359,436.4	355,814.1	(3,622.3)

Бараа материалын дансны үлдэгдэл 30,503.7 мянган төгрөг болж 4,963.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 23,203.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, сумын Засаг даргын тамгын газраас 4,000.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материал, Шаамар сумын онцгой комиссоос 102.5 мянган төгрөгийн халдваргүйжүүлэлтийн материал, БШУЯ-наас 185.8 мянган төгрөгийн эм боох материал, 2,856.7 мянган төгрөгийн аж ахуйн материал, БСУГ-аас 73.6 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 18,239.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 394,181.4 мянган төгрөг болж өмнөх оноос 6,889.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 6,500.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2,600.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 23.4 мянган төгрөгийн ном худалдан авч, БШУЯ-аас 2,490.0 мянган

төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, Шаамар сумын ИТХ-ын 2021 оны 12-р сарын 20-ны өдрийн 40 дүгээр тогтоолоор 1,670.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2,123.7 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 930.2 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хассанаас шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 355,814.1 мянган төгрөг болж 3,622.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 327,973.4 мянган төгрөг болж өмнөх оноос 17,136.7 мянган төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан байна. Энэ нь тусгай зориулалтын санхүүжилт, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өссөнтэй холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 331,595.8 мянган төгрөг болж өмнөх оноос 19,286.2 мянган төгрөгөөр буюу 5.5 хувиар буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 366,663.2 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 49,545.9 мянган төгрөгөөр бууруулж, **317,117.3 мянган** төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 317,117.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 291,728.3 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 25,389.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 291,728.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 23,354.2 мянган төгрөг нийт 315,082.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **298,578.8** мянган төгрөгийг зарцуулж, 16,503.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 298,578.8 мянган төгрөг буюу 94.2 хувьтай тайлагнагдсан байгаа нь цалин, НДШ-ийн зардал 11,648.1 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардал 2,034.7 мянган төгрөгөөр, нормативт зардал 4,512.0 мянган төгрөгөөр, томилолтын зардал 19.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 324.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгал, халдваргүйжүүлэлтийн зардалд 176.0 мянган төгрөг, сумын ЭМТ-өөс Ковидын үед ажилласан ажилтнуудын илүү цагийн хөлсөнд 766.1 мянган төгрөгийн санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

1. БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан “Түр журам журам батлах тухай ” тушаалын нэгдүгээр хавсралт “*Коронавируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам*”-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 124 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 21 мэдээллийг хугацаа хоцроон, 4 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаанд 317,117.3 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 298,578.8 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 5.8 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 289.5 мянган төгрөгийн төлбөрийн акт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгснөөс төлбөрийн актыг барагдуулж, зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	1	289.5	1	289.5	100
Зөвлөмж	1				
Нийт дүн	2	893.4	1	893.4	50

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 13,689.0 мянган төгрөгөөр шинээр нэмэгдэж, бүртгэгдсэн хөрөнгүүдийг биетээр тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар анхааран үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,353.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 192.9 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 3,160.2 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

4.1 Төлбөрийн акт

4.1.1 Эрхлэгч Ц.Болормаад ур чадварын нэмэгдлийг тогтоосон хувь хэмжээнээс илүү тооцож, 192.9 мянган төгрөг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх " *Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*", Шаамар сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн захирамж "Эрхлэгч Ч.Болормаа 25 хувь" гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1.Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 3,160.2 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ" гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг	2	3,353.1	-	-	1	192.9			1	3,160.2